



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Айраг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/06/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд 2022 он	Тэргүүлэх аудитор: Утас: 70522734	Т.Ган-Өлзий Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn
	Аудитын менежер: Утас: 70523020	У.Оюунтүлхүүр Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
	Гэрээт аудитор:	М.Дүүрэнжаргал Цахим хаяг: duurenjargalm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2022.02.25 № 16/274

танай _____ -ны № _____ -т

АЙРАГ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ
Х.БАЙГАЛЬМАА ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Айраг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Айраг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

This PC: D:/2022 onii ajil/A4 toot

01000005

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	81.4	262.1
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	645.7	731.4
	Нийт хөрөнгийн дүн	727.1	993.6
	Нийт өр төлбөрийн дүн	-	36.4
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	727.1	957.1
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	727.1	993.6
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	536.9	1,206.8
	Үйл ажиллагааны зардлын дүн	543.4	976.6
	Үйл ажиллагааны үр дүн	(6.4)	230.4
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	(0.6)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(6.4)	(230.0)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	362.1	362.1
	Тайлант оны үр дүн	295.5	525.5
	Эцсийн үлдэгдэл	727.1	957.1
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	494.8	627.5
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	488.0	614.2
	Үйл ажиллагааны ЦМГ	6.7	13.3
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(6.7)	(11.7)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	1.5
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	468.5	465.8
	Урсгал зардал	468.5	465.8
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	468.5	465.8
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	44.8	44.1
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	385.1	385.1

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Айраг сумын Эрүүл мэндийн төв нь сумын үйлчлэх хүрээний хүн амд эмнэлгийн анхан шатны болон яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх, нийгмийн эрүүл мэндийн боловсрол олгох зорилго тавин ажиллаж байна. Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Айраг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 266.5 сая төгрөгөөр буюу 26.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Айрагийн Эрүүл мэндийн төв нь шилэн дансанд дараах мэдээллийг оруулсан байна. Үүнд:

- 2021 онд шилэн дансны цахим системд 101 мэдээлэл байршуулахаас 101 мэдээлэл хугацаанд нь бүрэн,
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 275.1 сая төгрөгийн худалдан авсан бараа ажил үйлчилгээний мэдээллийг хугацаанд нь бүрэн,
- Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, санхүүгийн тайлан, аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, худалдан авах ажиллагааны мэдээллийг шилэн дансны цахим системд хуулиар тогтоосон хугацаанд тус тус бүрэн байршуулсан мэдээлсэн байна.

Тав. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татах асуудал гаргаагүй болно.

Зургаа. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 7,625.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс алдааг аудитын явцад залруулав.

Залруулсан алдаа:

1. Үр дүнгийн тайланд цалин хөлс болон ХЧТАТэтгэмжийн зардлыг 3,599.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгасан байна.

2. Цалингаас суутгасан НДШимтгэлийн зардалд 2,382.0 мянган төгрөгийн, ХАОАТатварын зардалд 1,540.6 мянган төгрөгийн, ҮЭ-ийн татварын зардалд 103.5 мянган төгрөгийн буюу нийт 4,026.1 мянган төгрөгийн илүү төлөлт хийсэн бөгөөд үүнийг авлагаар тусгаагүй байна.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ								

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	2	7.6	2	7.6	-	-				
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИЙТ	2	7.6	2	7.6	-	-				